



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/54

Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр (Алаг)-т байршилтай 5000м.кв (0.5 га) өвөлжөөний зориулалттай газрын эзэмшигч иргэн Ханд овогтой Цоодол (ЗЕ35081010) нь 2020 оны 11 дугаар сарын 01-ны өдөр нас барсан. Иймд охин Цоодол овогтой Отгонжаргал болон ач хүү Баярбат овогтой Дугаржав нарт уг газрыг зориулалтаар нь үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/99 тоот захирамжийн иргэн Х.Цоодол-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000692516 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

0006925162